

БАТЛАВ.	БАТЛАВ.	БАТЛАВ.
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
Э.БАТ-АМГАЛАН	С.БЯМБАЦОГТ	Б.ЭНХБАЯР
2026 оны ... дугаар сарын ...- ны өдөр	2026 оны ... дүгээр сарын ...- ны өдөр	2026 оны ... дүгээр сарын ...-ны өдөр

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь заалтад Монгол Улсын иргэн “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй,” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурал хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх чиг үүргийн хүрээнд хэд хэдэн бодлогын баримт бичиг батлан хот байгуулалтын талаар тодорхой зорилго, зорилтуудыг дэвшүүлсэн. Тухайлбал:

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.3-т “Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг иргэдийн аюулгүй ажиллаж амьдрах нөхцөлийг бий болгох зорилтод нийцүүлэн шинэчилж, хот байгуулалтад төлөвлөлтийг хатуу мөрдөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно” гэж, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 9.2-т “Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно.” гэж, 9.4-т “Хууль, эрх зүйн тогтвортой орчинтой, хотын дүрэм, стандартыг хангуулсан сайн засаглалтай хот болно” гэж заасан;

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Бүсчилсэн хөгжлийн бодлого гэсэн 1 дүгээр зорилтод “Бүс нутагт амьдрахад таатай нөхцөлийг бий болгох, хот, хөдөөгийн тэнцвэрийг хангах бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, иргэдэд таатай, эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц бүхий хотуудыг хөгжүүлнэ” гэж, 1.1.1.1-д ““20 минутын хот” буюу нийгмийн

дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулна” гэж, 1.1.1.2-т “Хот төлөвлөлт, орчны стандарт алдагдсан орон сууцны хорооллуудад газар чөлөөлөлт хийж, орчны төлөвлөлтийг стандартад нийцүүлнэ” гэж, 4.2.4.3-т “Хот байгуулалт, барилга, газрын талаарх холбогдох хуулийн уялдааг сайжруулж, төлөвлөлтөд суурилсан хот байгуулалтын тогтолцоог бий болгон, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрлийг олгож, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлагыг чангатгана.” гэж тус тус заасан.

Түүнчлэн Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 119-д “Хот байгуулалтын тухай хуулийн шинэчлэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж заасны дагуу тус хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

Тус хуулийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарт нийцэж байгаа болно.

1.2. Практик хэрэгцээ шаардлага

Монгол Улсын Их Хурлаас Хот байгуулалтын тухай хуулийг анх 1998 онд батлан мөрдүүлсэн бөгөөд хот байгуулалтын салбарын хөгжлийн чиг хандлагад үүссэн цаг үеийн шаардлагаар уг хуулийг 2008 онд шинэчлэн найруулж, баталснаас хойш нийт 9 удаа нэмэлт, өөрчлөлт орсон боловч тус хуулийг манай улсад нийгэмд эдийн засгийн хөгжил, хотжилт, бүтээн байгуулалтын үйл явц эрчимжсэнтэй холбоотойгоор хот байгуулалтын үйл ажиллагаа, нийгэм эдийн засгийн харилцаанд үүсээд буй өөрчлөлттэй уялдуулах, боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага бий болоод байна.

Хот байгуулалтын тухай хуулийн 2025 онд хийсэн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээнд дурдсанаар¹ тус хуулийн хэрэгжилтэд дараах асуудлууд тулгамдаж байна.

1. Хот байгуулалтын баримт бичгийн боловсруулалт, хэрэгжилтийн хүрээнд:

Хот байгуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлд хот байгуулалтын баримт бичигт 9 төрлийн баримт бичиг хамаарахаар заасан. Эдгээр баримт бичгийн суурь баримт бичиг болох Хүн ам амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн баримт бичиг 2008 оноос эхлэн боловсруулагдаж байгаа боловч уг баримт бичигт тусгагдсан бүсийн хөгжлийн чиг хандлагын хэтийн төлөв хэсэгт үндэслэн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг боловсруулж Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор баталсан байна. 2025 оны хагас жилийн байдлаар Монгол Улсын 330 сумын төв, суурин газраас хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй 146, төлөвлөгөө боловсруулагдаж байгаа 97, ерөнхий төлөвлөгөө боловсруулаагүй буюу хэрэгжих хугацаа нь дууссан нь 87 төв, суурин газар байна.² Зарим суурин газар хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлаагүй байгаа нь орон нутгийн төсөвт санхүүжилтийн эх үүсвэр тусгагддаггүйгээс шалтгаалж байна. Ийнхүү хуулийн хэрэгжилтийг сайжруулах хүрээнд хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, батлах ажлыг гүйцэтгэх хугацаа, хяналт шинжилгээ хийх, тодотгол хийх, хэрэгжүүлэх журам, ажлын дараалал, хэрэгжилтийн үе шатыг зааглах, тэдгээрийн

¹ ХББОСЯ, Хот байгуулалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, 2025

² Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны танилцуулга

санхүүжилтийг шийдвэрлэх зэрэг харилцааг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлага үүсэж байна.

-Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь Монгол Улсын хууль тогтоомжоор нийслэл хотын, бүсийн хөгжлийн тулгуур төв хотын, улсын зэрэглэлтэй хотын, орон нутгийн зэрэглэлтэй хотын, нийслэлийн дагуул хотын, нийслэлийн тусгай бүсийн гэсэн 6 дэд хэлбэртэй байхаар заасан боловч эдгээрийн хоорондын уялдаа, эрэмбийг хуулиар нарийвчлан зааглах шаардлага үүссэн байна. Мөн улсын зэрэглэлтэй хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах субъектийг Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэмж тусгах нь зүйтэй байна.

-Хот байгуулалтын баримт бичгийг ач холбогдлоор нь нутаг дэвсгэрийг хөгжүүлэх төлөвлөлтийн болон хот, тосгон, суурин газрыг хөгжүүлэх төлөвлөлтийн баримт бичиг гэж ангилж, хот байгуулалтын баримт бичгүүдийн төрлийг зөв тодорхойлох, баримт бичгүүдэд тавигдах шаардлагыг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлага байна. Тухайлбал, барилгажилтын төслийг хот байгуулалтын баримт бичигт хамруулах, тавигдах шаардлагыг хуулиар тодорхойлоогүй байгааг өөрчилж Хот байгуулалтын тухай хуулиар уг асуудлыг зохицуулах практик хэрэгцээ, шаардлага үүссэн.

-Хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд хот байгуулалтын үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог хэт ерөнхий байдлаар тусгасан бөгөөд хот байгуулалтын үйл ажиллагааны үе шат бүрд хяналт шинжилгээ хийх, үнэлгээ гаргах, үнэлгээний үр дүнг тайлагнаж холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх асуудлыг зохицуулаагүй байна. Иймд хот, тосгон, суурин газрыг төлөвлөх, хот байгуулалтын бүсчлэлийг тогтоох, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу барьж байгуулах, хөгжүүлэх явцад хяналт, шинжилгээ, үнэлгээг хийх бодит тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

-Хот байгуулалтын баримт бичиг, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний уялдааг сайжруулах хүрээнд газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь холбогдох хот байгуулалтын баримт баримт бичигтэй нийцсэн байх зарчим, эрэмбэ, уялдааг Хот байгуулалтын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулах шаардлагатай.

2.Төрийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийн хүрээнд:

-Монгол Улсад хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /агентлаг/ байгуулагдаагүй байна. Үүний улмаас хот байгуулалтын бодлогын хэрэгжилтийг хангах, төрийн үйлчилгээг тасралтгүй хүргэх, холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг нийтээр мөрдүүлэх, хот төлөвлөлт, байгуулалтын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх, орон нутаг дахь хот байгуулалтын асуудал эрхэлсэн албыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах зэрэг үйл ажиллагаанд тогтолцооны болон хүний нөөцийн, чиг үүргийн хүндрэл үүсэж байна. Иймд Хот байгуулалтын тухай хуульд хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны болон хот байгуулалтын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг, хүлээх хариуцлагыг тусгаж, тус салбарын тулгамдсан асуудлуудыг цаг алдалгүй шийдвэрлэх, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

- Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т аймаг, нийслэлийн Засаг дарга нь ерөнхий архитектораар удирдуулсан Хот байгуулалт,

барилга захиалагчийн албыг байгуулахаар заасан боловч уг заалт бүрэн хэрэгжихгүй байна. 2025 оны байдлаар 21 аймгийн Ерөнхий архитекторын 12 нь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, 9 нь аймгийн Засаг даргын тамгын газарт харьяалагдсан газар, хэлтсийн дарга, мэргэжилтэн зэрэг өөр албан тушаалын ангилал, зэрэглэл дээр ажиллаж байна. Мөн Ерөнхий архитекторт тавигдах мэргэжил, мэргэшил, туршлагын шаардлагыг хуулиар тодорхойлон заагаагүйгээс мэргэжлийн бус хүн уг албан тушаалыг эрхлэх асуудал зарим тохиолдолд гарч байна.³ Иймд Хот байгуулалтын тухай хуульд Ерөнхий архитекторт тавигдах мэргэжил, мэргэшил, туршлагын шаардлага, албан тушаалын ангилал, зэрэглэл, сонгон шалгаруулах журмыг нэг мөр зохицуулах шаардлага үүсэж байна.

-Аливаа хот, тосгон, суурин газарт хот байгуулалтын бүхий л үйл ажиллагаа явагдаж, түүний үр дүнд оршин суугчдын эрүүл, аюулгүй орчин нөхцөлд ажиллаж, амьдрах эрхийн баталгаа хангагдаж байдаг тул тухайн шатны Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хот, тосгоны Захирагч, хот, тосгоны Зөвлөл, түүнчлэн орон нутгийн хот байгуулалтын асуудал хариуцсан албаны хот байгуулалтын талаар хэрэгжүүлэх эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой хуульчлах шаардлага практикт үүсэж байна.

3. Хот байгуулалтын бүсчлэлийн хүрээнд:

Хот байгуулалтын тухай хуульд бүсчлэлийн нийтлэг дүрмийг болон хотын бүсчлэлийн тухайлсан дүрмийг баталж мөрдүүлэх субъектийг хуульчлаагүй нь хэрэгжилт хангалтгүй байгаагийн нэг шалтгаан болж байна. Газрын тухай хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хотын бүсчлэлийн дүрмийг батлахаар заасан боловч уг зохицуулалт Хот байгуулалтын тухай хуульд нэгдсэн байдлаар тусгагдаагүй байх тул бүсчлэлийн нийтлэг дүрмийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас батлах зэрэг харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай байна.

4. Хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогчдын чиг үүрэг, эрх зүйн байдлын хүрээнд:

Иргэдийг эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдруулахад чиглэсэн хот байгуулалт, газрын харилцааны бодлого, зохицуулалтын нэгдмэл байдлыг хангах, эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлэх, хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч, хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг болон хот төлөвлөлтийн мэргэжлийн байгууллага, мэргэжилтний ёс зүй, хариуцлагын талаарх зохицуулалтуудыг тодорхой болгож, сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.

5. Олон нийтийн оролцоог хангах хүрээнд:

Хот, тосгон, суурин газрын газрыг төлөвлөх, зохион байгуулах, хөгжүүлэх, хөрөнгө оруулах шийдвэр гаргах үйл ажиллагааг нээлттэй, олон нийтийн оролцоотой, тэгш үйлчлэх агуулгыг хэт ерөнхий байдлаар тусгасныг өөрчилж, нийтийн эрх ашгийг хамгаалах, хүн амьдрах таатай орчныг бүрдүүлэхийн тулд иргэд, аж ахуй эрхлэгч, газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгч болон эрх бүхий албан тушаалтны үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, хот төлөвлөлт, хот байгуулалтын

³ Аймаг, Нийслэл, хотын ерөнхий архитекторуудын эзэмшсэн мэргэжил, мэргэшлийн түвшингээр судалгаа хийхэд Хот төлөвлөлтийн архитектор -1, Хот ба бүс нутаг төлөвлөлт -2, Хот төлөвлөгч -1, Архитектор -9, Ландшафтын архитектор -4, Барилгын инженер -3, Дулаан сан техникийн инженер -1, Газар зохион байгуулагч -1 байгаа бөгөөд мэргэшсэн инженер -3, мэргэшсэн архитектор -8, хот төлөвлөлтийн мэргэшсэн архитектор -2, доктор -1 байна.

үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нарийвчлан зохицуулах шаардлага бий болоод байна.

6.Бусад асуудлын хүрээнд:

Хот байгуулалтын баримт бичгийн магадлал хийх үе шат, зохион байгуулалт, хот төлөвлөлтийн норм, нормативын тогтолцоо, санхүүжилт, зөвлөх үйлчилгээ, хот байгуулалтын үйл ажиллагаанд тавих төрийн болон олон нийтийн хяналтыг сайжруулах, хот суурины барилгажилт, бүсчлэл, түүнтэй холбоотой арга хэмжээг төлөвлөх, тавигдах шаардлага, зөвшөөрлийн харилцааг хуульд нарийвчлан тусгах, хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн санг бэхжүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах асуудлыг боловсронгуй болгон зохицуулах хэрэгцээ шаардлага практикт тулгамдаж байна.

Түүнчлэн Хот байгуулалтын тухай хуулийг бусад хууль тогтоомж, эрх зүйн акттай уялдуулах ажлын хүрээнд тус хуулийн хийдэл, давхардал, зөрчлийн судалгаа 2025 онд хийгдэж, нийт 56 давхардал, хийдэл, зөрчил байна гэж⁴ дүгнэсэн байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.3-т “хуулийн үзэл баримтлалыг бүхэлд нь өөрчлөхөд хүргэсэн нэмэлт, өөрчлөлт орох бол;”, мөн зүйлийн 25.1.4-т “тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон” тохиолдолд хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна гэж заасны дагуу дээр дурдсан хууль зүйн үндэслэл, практик шаардлагын дагуу Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төслийн зорилт нь Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хүн амын эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас сэргийлсэн бүс нутаг, хот, тосгон, суурин газрыг төлөвлөх, байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хуулийн төсөлд дараах асуудлыг зохицуулахаар тусгана. Үүнд:

1/хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, зохицуулах харилцаа, нэр томъёоны тодорхойлолт, хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагаанд баримтлах зарчим зэрэг нийтлэг харилцааг зохицуулна.

2/хот байгуулалтын баримт бичгийн ангилал, төрөл, тэдгээрт тавигдах шаардлага, хот байгуулалтын баримт бичгийг боловсруулах санхүүжилтийн эх үүсвэр, баримт бичигт магадлал хийх, дагаж мөрдөх дүрэм, журам, аргачлалын талаар зохицуулна. Хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, бүсийн хөгжлийн төлөвлөгөө, салбарын хөгжлийн төсөл, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг нутаг дэвсгэрийг хөгжүүлэх төлөвлөлтийн баримт бичигт хамаарахаар, хот, тосгон, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө,

⁴ ХББОСЯ, Хот байгуулалтын тухай хуулийн давхардал, зөрчил, хийдлийн судалгаа, 2025.

хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, хот, тосгон, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийг хот, тосгон, суурин газрыг хөгжүүлэх төлөвлөлтийн баримт бичигт хамаарахаар тус тус заана.

3/хот байгуулалтын бүсчлэлийн суурь зохицуулалтыг нарийвчлан тодорхойлж, бүсчлэлийн төрөл, ангилал, тавигдах шаардлага, зөвшөөрөх, хориглох үйл ажиллагаа болон бусад холбогдох зохицуулалтыг нарийвчлан тусгана.

4/хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үе шатын талаар тусгаж, хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, бүсийн хөгжлийн төлөвлөгөө, хот, тосгон, суурин газрын хөгжлийн төлөвлөлтийн үе шатны баримт бичгийг боловсруулах, зөвшилцөх, батлах үе шат, тэдгээрт тавигдах шаардлагатай холбоотой зохицуулалтыг тодорхойлно.

5/хот байгуулалтын талаарх төрийн байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, бүрэн эрхийг тогтооно. Тухайлбал, Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, хотын Зөвлөл, Захирагчийн чиг үүрэг, түүнчлэн Ерөнхий архитектор, орон нутаг дахь хот байгуулалтын асуудал эрхэлсэн албаны чиг үүрэг, хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч төрийн бусад байгууллагын чиг үүргийг тодорхойлно.

6/хот байгуулалтын салбарын мэргэжилтний ёс зүй, мэргэшлийн зэрэглэл, сургалтад тавигдах шаардлага, нөхцөлийг тусгаж, энэ салбарт үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд, төрийн бус байгууллага, хот байгуулалтын баримт бичгийн захиалагч, гүйцэтгэгч, хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг, хариуцлага, баримт бичигт тавигдах хяналтын тогтолцооны талаар тусгана. Мөн хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөл олгох, бүртгэх, зураг төслийн магадлал хийх үйл ажиллагааны зохион байгуулалт, хяналтын талаар тусгана.

7/хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцооны талаар нарийвчлан тусгана.

8/хот байгуулалтын кадастр, хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн сан, түүнийг эрхлэх удирдлага, зохион байгуулалт, ил тод байдлын талаар тусгана. Тухайлбал, хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн сангийн иж бүрдэл, агуулга, мэдээлэл солилцоо, хөтлөлт, хөгжүүлэлт, тэдгээрийг хариуцан хэрэгжүүлэх байгууллагын чиг үүргийг тусгана.

9/хот байгуулалтын тусгай зохицуулалттай хамааралтай осол, гамшгийн үеийн зохицуулалт, хот байгуулалтын төсөв, санхүүжилт, хот байгуулалтын үйл ажиллагааны хэрэгжилт, түүнд тавигдах хяналт, үнэлгээний асуудлыг тусгана.

10/хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох зохицуулалтыг тусгана.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар хот, тосгон, суурин газар болон улс, бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилтийг хангах эрх зүйн зохицуулалт олон улсын жишигт нийцэх

бөгөөд байгаль орчин, нийгэм, эдийн засаг, хууль зүйн хувьд дараах эерэг үр дагавар бий болно. Үүнд:

- Хот байгуулалтын салбарт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах үндсэн эрхийг эрх зүйн орчин бий болно;

- Бүс нутаг, хот, тосгон, суурин газрын хөгжлийн төлөвлөлт, бүтээн байгуулалтын үйл ажиллагааны талаарх бодлого, хэрэгжилтийн зохицуулалт нь нэгдмэл болж, хот байгуулалтын талаарх хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил арилах, хот, суурин газрууд хөгжих нөхцөл бүрдэнэ;

- Хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, үйл ажиллагааг нээлттэй ил тод болгох, хэрэгцээ, шаардлагад илүү нийцсэн, хүрээлэн буй байгаль орчинтойгоо харилцан уялдаа холбоо бүхий ногоон хөгжлийн шаардлагыг хангасан, ногоон хот байгуулалт бий болох нөхцөл бүрдэнэ;

- Хот байгуулалтын үйл ажиллагааг бүсчлэлийн хэлбэрээр зохицуулан, холбогдох мэргэжлийн байгууллага, бүсчлэлийн зөвлөлийн саналыг урьдчилж тусгах нь байгаль орчинд ээлтэй буюу хот, тосгон, суурин газрын нөөцийг оновчтой тооцоолсон, хөрөнгө оруулалтын бодлогод суурилсан, улсын хөгжлийн нэгдсэн бодлогод нийцсэн хот байгуулалтыг бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ;

- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг харилцан уялдуулснаар хот, тосгон, суурин газрын тэлэлт, шаардлагагүй дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, одоогийн үүсээд буй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэнэ;

- Хот, тосгон, суурин газрын газар ашиглалтын зөв хуваарилалт бий болж, хот төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, түүний бүрэлдэхүүн хэсэг, хэрэгжүүлэх үе шатыг тодорхой болгосон эрх зүйн зохицуулалт бүрдэнэ;

- Хот байгуулалтыг төлөвлөлтийн үе шатнаас эхлэн хэрэгжүүлж дуусах хүртэл хугацаанд хууль тогтоомж, норм, нормативын шаардлагыг хангаж ажиллах нөхцөл бүрдэнэ;

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Газрын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Зөвшөөрлийн тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Зөрчлийн тухай, Барилгын тухай, Чөлөөт бүсийн тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай, Хүннү хотын эрх зүйн байдлын тухай, Монгол Улсын

нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай, Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүнчлэн Хот байгуулалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хот байгуулалтын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, хууль батлагдсантай холбогдуулах авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон шаардлагатай бусад хууль тогтоомжийн төслийг боловсруулна.

---oo0oo---